



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 18 өдөр

Дураар А/597

Булган сум

Бэлчээр хамгаалах арга хэмжээг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2023 оны "Глийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь батлах тухай" А/143 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ургамал хамгаалал эрдэм шинжилгээний хүрээлэнгээс гаргасан бэлчээрийн хөнөөлт мэргч амьтны тархалт, хөнөөлийн судалгааны дүгнэлтийн дагуу энгийн механик, биологийн аргаар тэмцэх арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баян-Алт, Баяннуур, Бүрэхангай, Сайхан, Рашаант, Дашинчигэн, Гурванбулаг сумдын бэлчээрийн 30.0 мянган га талбайд энэ оны 11 дугаар сарын 15-наас 11 дүгээр сарын 30-ний өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Уг арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг сайтар хангаж, ажиллах хүн, хүч, техник хэрэгсэл дайчлах, малчдыг өргөнөөр оролцуулж, шуурхай зохион байгуулахыг холбогдох сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх сумын Засаг даргатай гэрээ байгуулж, хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулж, мэргэжил аргагүйн зөвлөмжөөр хангаж хяналт тавьж ажиллахыг Хүнс, Хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2023 оны А/265 дугаар захирамжийн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх хуваарийг хүчингүй болгонд тооцсугай.



ЗАСАГ ДАРГА
Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010922
Sugat Ажил 2023 өдөр бүр Doc/2023/Захирамж